



ЦАХИМ НОТАРИАТЫН СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ АЛХАМ

1. Цахим хуудсанд нэвтрэх

consul.notary.mn цахим хуудсанд нэвтэрнэ.

2. Бүртгэл үүсгэх

consul.notary.mn цахим хуудсанд нэвтрэн орсны дараа "Шинээр бүртгэл үүсгэх" товчыг дарна.

3. Мэдээллээ оруулах

Дээрх зургийн дагуу хувийн мэдээллээ /Кирил үсгээр/ бүрэн гүйцэд, зөв оруулсны дараа "Бүртгэл үүсгэх" товчыг дарна. Бүртгэл амжилттай хийгдсэний дараа Таны цахим шуудангийн хаягаар системд нэвтрэх нууц үг илгээгдэх бөгөөд системд "Нэвтрэх нэр" нь Таны бүртгүүлсэн цахим шуудан болно.

Хэрэв Таны цахим шууданд нууц үг ирээгүй тохиолдолд ЭСЯ-ны фэйсбүүк хуудас болон **+49 30 47 48 06 22(23)** дугаарын утсаар холбогдохыг зөвлөж байна.





ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ АЛХАМ

1. Цахим хуудсанд нэвтрэх
consul.notary.mn цахим хуудсанд өөрийн бүртгэлээр нэвтэрнэ.

2. Загвар, төрлөө сонгох
Өөрийн үйлдэх итгэмжлэлдээ тохирох загвар, төрлийг сонгоно.

3. ЭСЯ-ыг сонгох
Дипломат төлөөлөгчийн газар гэсэн сонголтоос "Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа ЭСЯ" гэснийг сонгоно.

4. Үндсэн мэдээлэл оруулах

Нэвтрэх нэр

Нууц үг

Баталгаажуулах Дипломат төлөөлөгчийн газар : * Берлин. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад ...

1 Үндсэн мэдээлэл 2 Итгэмжлэлээр олгох эрх 3 Бусад нөхцөл 4 Хавсралт 5 Үйлдэл харах

Баталгаажуулах Дипломат төлөөлөгчийн газар : * Берлин. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад ...

Төлөөлүүлэгч

Гадаадад байгаа Монгол Улсын иргэн

Улс : * Герман Улс

Хот : * Хот/Аймаг

Гадаадад оршин суугаа хаяг : * Тайлбар

Шинэ төлөөлүүлэгч нэмэх

Төлөөлүүлэгч гэдэг нь итгэмжлэл үйлдэж буй Та бөгөөд энэ хэсэгт Таны мэдээлэл автоматаар гарна. Улс гэсэн сонголтоос **Герман улсыг** сонгож Герман улс дахь өөрийн хаягийг кирил эсвэл латин үсгээр бичнэ. Хэрэв Та энэхүү итгэмжлэлийг өөр хэн нэгэнтэй хамтран гаргаж байгаа тохиолдолд "**Шинэ төлөөлүүлэгч нэмэх**" гэсэн сонголтыг дарж, хамтран итгэмжлэл гаргаж буй хүний мэдээллийг оруулна. **Төлөөлөгч** гэдэг нь Таны итгэмжлэлийг хүлээн авах хүн юм.

Хэрэв Таны итгэмжлэлийг нэгээс илүү Төлөөлөгч авах шаардлагатай тохиолдолд "**Шинэ төлөөлөгч нэмэх**" гэсэн сонголтыг дарж, Төлөөлөгчийн мэдээллийг оруулна. Төлөөлөгчийн мэдээллийг бүрэн гүйцэд оруулсны дараа "**Дараах**" товчыг дарж, дараагийн хуудсанд шилжинэ.





ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ АЛХАМ

5. Эрх олгох

Энэхүү хэсэгт Та итгэмжлэл хүлээн авах Төлөөлөгчөөр ямар үйлдэл хийлгэх эрх олгож байгаагаа үйлдэл тус бүрээр нь сонгоно. Хэрэв Таны олгох эрх жагсаалтад байхгүй тохиолдолд тохирох хэсгээс **"Бусад"** гэсэн сонголтыг сонгож, нэмэлтээр гарч ирэх цонхонд Төлөөлөгчид олгох эрхээ тодорхой бичнэ. 18 нас хүртэлх хүүхдийн итгэмжлэлийг Эцэг/Эх хийх бөгөөд Бусад хэсэгт хүүхдийн **"Овог, Нэр, Регистрийн дугаар"** заавал бичнэ үү.

6. Итгэмжлэлийн хугацаа

Итгэмжлэлийн хугацаа /Тоогоор/ : *

Хүчинтэй хугацаа/Тоогоор/

Тайлбар: "Олгосон өдрөөс хойш 3 жил хүртэл хугацааг сонгож тавина уу. 14 хоног, 1 сар, 2 жил."

Хугацаа : *

Хоног

Тайлбар: "Олгосон өдрөөс хойш 3 жил хүртэл хугацааг сонгож тавина уу. 14 хоног, 1 сар, 2 жил."

Итгэмжлэлийн хугацаа /Үсгээр/ : *

Хүчинтэй хугацаа/Үсгээр/

Тайлбар: "Олгосон өдрөөс хойш 3 жил хүртэл хугацааг сонгож тавина уу. 14 хоног, 1 сар, 2 жил."

Төлөөлөх эрхийг бусдад шилжүүлэх : *

эрхгүй

Итгэмжлэлийн хүчинтэй хугацааг тоогоор тавьж, **"Хугацаа"** хэсгээс тохирох сонголтыг хийнэ. Итгэмжлэлийн хүчинтэй хугацаа дээд тал нь **3 жил** байна.

7. Файл хавсаргах

Хавсралт +



Анхааруулга! Гадаад паспорт захиалах бол заавал иргэний үнэмлэхийн хуулбар хавсаргана уу? Хавсралт файлыг зөвхөн зургаар оруулна уу?

Д/д	Төрөл	Файл	Нэр	Хэмжээ	Устгах
1.	--Choose your Content type--	Файл оруулах	Файл сонгоогүй	0 Кб	

Төлөөлүүлэгч буюу итгэмжлэл олгож буй Таны **иргэний үнэмлэх/гадаад паспортын** хуулбар зайлшгүй шаардлагатай тул **"Файл оруулах"** товчыг дарж, бичиг баримтын хуулбарыг заавал хавсаргана. Мөн тухайн итгэмжлэлд холбогдох баримт бичгийг хавсаргах шаардлагатай. Тухайлбал, хүүхэдтэй холбоотой итгэмжлэлд хүүхдийн төрсний гэрчилгээ, эд хөрөнгөтэй холбоотой итгэмжлэлд тухайн хөрөнгийн гэрчилгээний лавлагаа/баталгаат хуулбар зэрэг болно.






ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ АЛХАМ

8. Итгэмжлэл илгээх

Итгэмжлэлээ сайтар уншиж, хянасны дараа баталгаажуулах **"Тийм"** товчыг дарснаар итгэмжлэл ЭСЯ руу илгээгдэнэ. ЭСЯ-наас итгэмжлэлийг хянаж, нэмэлт мэдээлэл оруулах, засах тохиолдолд Таны цахим шуудан руу илгээх бөгөөд энэ тохиолдолд нотариатын системийн **"Миний үйлчилгээ"** цэсийн **"Хянуулах хүсэлт"** хэсэгт итгэмжлэл нь **"Буцаасан"** гэсэн төлөвтэй байна.

Итгэмжлэлийг **"ХЯНУУЛАХ"**-аар илгээсний дараа ЭСЯ-ны цаг авах хэсгээр урьдчилан цаг авч үйлчлүүлнэ. Цаг аваагүй иргэдэд үйлчлэх боломжгүйг анхаарна уу.

ЭСЯ итгэмжлэлийг баталгаажуулсаны дараа **"Баталгаажсан хүсэлт"** хэсэгт байх итгэмжлэлийн төлөв **"Архивлагдсан"** төлөвт шилжих ба хойш гүйлгэж **"Харах"** товчыг дарж баруун доод буланд байрлах QR кодыг төлөөлөгчид илгээнэ.



Мөн итгэмжлэл хүлээн авах төлөөлөгч, өөрийн **"e-mongolia"**-аас итгэмжлэл олгогдсон эсэхийг хянах боломжтой.

Төлөөлөгч өөрт хамгийн ойр Нотариатын газраас итгэмжлэлээ хүлээн авна.

